

МЦХ ХК-ийн 2018 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан

Нэг. Үйл ажиллагааны төлөвлөгөө, стратегийн хэрэгжилт

МЦХ ХК нь 2018 онд “Бизнесийн бүтцэд шинэчлэл хийх”, “Менежментийн үйл ажиллагаа, дотоод харилцааг сайжруулах”, “Хэрэглэгчийн үйлчилгээг сайжруулах” чиглэлүүдээр 144 ажил төлөвлөн хэрэгжилтийг тухай бүр хянан ажилласнаар биелэлт 80.5 хувийн биелэлттэй ажиллаж байна.

Дээрх ажлуудаас 4 ажлыг бие даасан төсөл хэлбэрээр зохион байгуулж, хэрэгжүүлж байна. Үүнд:

А. Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх зорилтын хүрээнд

Компанийн салбар нэгжийн байршил, хүн хүч, техник, технологийн нөөцийг судлан “Хүргэлтийн О2О” төслийн бизнес төлөвлөгөөг боловсруулан, танилцуулж, ТУЗ-аас цаашид төслийн үндсэн платформыг хэрхэн хөгжүүлэх, уг төслийг удирдан зохион байгуулах ажлын баг, техник технологийн нөөцийг хэрхэн уялдуулан зохицуулах талаарх нарийвчилсан судалгаа, тооцооллыг хийж хэрэгжүүлэх чиглэлийн дагуу судалгааны ажил хийгдэж байна,

Media customer нэмэгдүүлэх OTT үйлчилгээг судлах, зах зээлд нэвтрүүлэх төслийн баг тус үйлчилгээг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн орнуудын туршлагыг судлах зорилгоор БНСУ-ын 2 компанитай уулзалт зохион байгуулж мэдээлэл цуглуулж, цаашид OTT үйлчилгээг нэвтрүүлэх зах зээлийн судалгаа, компанийн хөрөнгө оруулалтын тооцооллыг боловсруулахаар ажиллаж байна,

Төрийн үйлчилгээний дижитал шилжилтэд оролцох төслийн хүрээнд: Төрийн мэдээллийн цахим үйлчилгээний хамгийн их ачаалал авч байгаа 5 байгууллагын нийт 500 гаруй нэр төрлийн мэдээлэл лавлагааны үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх компанийн өнөөгийн нөөцийн судалгааг хийж, оператор компанийн оролцоотойгоор ажиллах саналаа боловсруулан ХХМТА-г хүргүүлээд байна

Б. Хэрэглэгчийн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилтын хүрээнд

2018 онд интернэт хэрэглэгчдэд төвлөрөн үйл ажиллагааны бүх түвшинг жигд сайжруулах зорилгоор интернэт хэрэглэгчдийн өртгийг өсгөхгүйгээр хурдыг “+1” нэмэгдүүлэх, суурин утас болон кабелийн телевизийн хэрэглэгчдэд “+1” хөнгөлөлт, урамшуулал олгох замаар урт хугацаанд тогтоон барих, сэтгэл ханамжтай үйлчилгээ хүргэх, цаашид дотоодын зах зээлд хүчтэй өрсөлдөх чадварыг бий болгохоор “+1” хөтөлбөрийн боловсруулан, эхний шатанд ARPU өндөр албан байгууллагуудад чиглэсэн 821 албан байгууллага, орон нутагт 1551 албан байгууллагад тус тус хүрч ажиллалаа. Техникийн өргөтгөл хийснээр үргэлжлүүлэн Улаанбаатар хотод 1878 албан байгууллага, орон нутагт 1482 албан байгууллагад ажиллагаа явуулахаар ажиллаж байна.

В. Үйл ажиллагааны төлөвлөлтийн хүрээнд

Үндсэн үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлж, зах зээлээ хадгалах зорилгоор хуулийн этгээд аж ахуйн нэгж рүү чиглэсэн хэрэглэгчдэд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ хүргэх, өндөр хурдны интернэтийн хэрэглээг нэмэгдүүлэх, өрхөд чиглэсэн суурин утасны болон КаТВ-ийн үйлчилгээг дуу, дүрс, долгионы чанар, тоо хэмжээний хувьд нэмэгдүүлэх чиглэлээр:

- Монгол даатгал ХХК, Аметрос солюшн ХХК, Хаан банк зэрэг байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, техник, технологийн ажил хийгдэж, тайлант хугацаанд орлогыг 37 хувиар нэмэгдэж, УБ хотын бодит интернэт хэрэглэгчийн тоо 6%, хуваагдсан хурдны байгууллагын тоо 2 дахин, орон нутгийн хэрэглэгчийн тоо 1,7 хувиар тус тус өссөн байна,
- Онлайнар хэрэглэгч өөрийн хэрэглээг хянах, төлбөр төлөх, бүтээгдэхүүн үйлчилгээний захиалга өгөх, компанийн зүгээс өгч буй мэдээ, мэдээлэлтэй танилцах, төлбөрийн дэлгэрэнгүй мэдээлэл харах зэрэг боломжтой вэб сайт, гар утасны аппликэйшнтэй цогц систем нэвтрүүлэх,
- Хэрэглэгчийн дуу хоолойг (Voice of Customer) бүртгэх, хянах, гомдол барагдуулах процессын хяналт, гүйцэтгэлийг автоматжуулах хэрэглэгчийн удирдлагын систем нэвтрүүлэх зэрэг программ хангамжийн томоохон төслүүдийн судалгаа, тооцооллын ажлууд хийгдэж байна,
- Тоон телевизийн өргөтгөл хийж шинээр студи байгуулах ажлын хүрээнд : Хэнтийн Бор-өндөр суманд нийт хэрэглэгчдийн 95 хувь шилжиж, Хөвсгөл аймагт 150 гаруй хэрэглэгчтэй болоод байна. Булган аймагт Булган аймагт агаарын сувгийн тоон телевизийн үйлчилгээг нэвтрүүлэх боломжийн судалгааг хийж бэлтгэл ажлыг хангах тал дээр ажиллаж байна,
- Төлбөр тооцооны нэгдсэн систем нэвтрүүлж, техникийн найдвартай ажиллагааг хангах, үйлчилгээг уян хатан, өрсөлдөхүйц байдлаар хүргэх боломж бүрдүүлэх зорилгоор “U-Angel” ХХК-тай хамтран ажиллаж байна.

Г. Хэрэглэгчийн үйлчилгээний чанарыг сайжруулж, хэрэглэгчээ тогтоон барих зорилгоор

Хэрэглэгчийн үйлчилгээний чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлж, зөвшөөрөгдөх түвшинг тооцоолон тогтоож, улирал бүр мэдээллийг гаргаж байна: Тухайлбал,

- Шугамын 100 цэгт ногдох гэмтлийн хувь 128%;
- Өдөртөө засагдсан гэмтлийн хувь 99%;
- Амжилттай дуудлагын хувь 96.3%;
- Амжилттай холболтын хувь 100%,
- Үйлчилгээний стандартын үзүүлэлт 78%,
- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үзүүлэлт 88%

Хэрэглэгчийн үйлчилгээний чанартай холбоотой гомдлын ангиллыг тодорхойлсноор гомдлын дийлэнх хувийг төлбөртэй холбоотой гомдол байгааг тогтоон, автоматжуулах, системийг боловсронгуй болгох, и-мэйлээр, сошиал сувгуудаар мэдээлэл хүргэх ажлуудыг хэрэгжүүлж байна. Эхний хагас жилд төлбөртэй холбоотой гомдол 2,685 байснаа 2,612 болж буурлаа.

Сүүлийн 3 жилд нийт гэмтлийн тоо буурсан, үүнээс шугамын гэмтлийн тоо буурахаас гадна гэмтлийн үргэлжлэх, хугацаа, шугамын гэмтлийн засварын дундаж хугацаа буурч эерэг хандлага гарч байна.

Хэдийгээр суурин утасны хэрэглэгчийн тоо буурч байгаа боловч 2017 оны II улирлаас эхлэн хэрэгжүүлсэн станцын шилжүүлгийн ажилтай холбогдуулан Улаанбаатар хот, орон нутгийн хэрэглэгчдэд нэмэлт үйлчилгээг санал болгох боломжтой болж, үйлчилгээний заалаар үйлчлүүлж буй шинэ болон хуучин хэрэглэгчдэд онцлох 2 нэмэлт үйлчилгээг “заавал” санал болгох, идэвхжүүлэх, улмаар суурин утасны орлогыг нэмэгдүүлэх, хэрэглээг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Лавлагаа дуудлагын төвийн мэдээллийн санд цаг үеийн чанартай мэдээллүүдийг тухай бүр нь оруулахаас гадна шинээр Замын хөдөлгөөнийг удирдах төвийн ачигдсан машины мэдээллийг өгөх төрөл нэмэгдүүллээ.

Хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэх зорилгоор тайлант хугацаанд 44 чиглэлд шилэн кабелийн хайгуулын ажил хийгдлээ.

Интернэтийн үйлчилгээ, хурдыг сайжруулах зорилгоор Улаанбаатар хотын XIII-ний эсэргүүцэл муутай гол болон салбар кабелийн чанарын дүгнэлт гаргаж, GPON сүлжээний шилэн кабелийн өргөтгөлийн болон тоног төхөөрөмжийн тоо, хэмжээ, төлөвлөлтийн зураглал тоо хэмжээг гаргаж, сүлжээнд шилжүүлэх төслийн ажлыг хийж байна.

Төрөөс иргэдэд хүргэдэг үйлчилгээг хамгийн дөт, шуурхай, нээлттэй, хяналттай тогтвортойгоор хүргэх зорилго бүхий “Төрийн цахим үйлчилгээ” төслийн хүрээнд төрийн мэдээлэл солилцооны “ХУР” систем болон программыг хөгжүүлж, ажилд оруулснаар уг системтэй VPN сүлжээний холболт хийгдэж системээс мэдээлэл авах бүрэн боломжтой болсон.

Билл төлбөрт үйлчилгээгээ QPay үйлчилгээнд нэвтрүүллээ.

Нийт хэрэглэгчдээ зориулсан сугалааны програм хийж дуусгаад нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Тайлант хугацаанд бүтээгдэхүүн үйлчилгээний цэгийн гүйцэтгэл суурин утас 98.4%, интернэт 88.7%, кабелийн телевиз 100.1%, үүнээс Улаанбаатар хотын нийт бодит хурдны интернэт хэрэглэгчийн тоо **106%** болсон үр дүн харагдаж байна.

Хоёр. Хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилт


2018 оны зорилго, зорилтоо хэрэгжүүлэхэд 5.3 тэрбум төгрөгийн төсвийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөн эхний 6 сарын байдлаар ХҮБ-ээр дараах дүнтэй байна.

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Төсөвт өртөг /мян. төг/	2018 ХБГ /мян. төг/	Хувь /%/
1	Суурин утасны хуучин станцуудыг дараа үеийн (NGN) технологиор солих	594,911	593,565	99.77%
2	Програм хангамжийн шинэчлэл	1,360,000	1,250,000	91.91%
3	Интернэтийн сүлжээний багтаамжийн өргөтгөл /Булган аймгийн төв, Өвөрхангай аймгийн Хархорин суманд агаарын олон сувгийн телевизийн үйлчилгээ нэвтрүүлэх төсөл/	304,810	289,569	95.00%
4	GPON сүлжээний өргөтгөл /Улаанбаатар хот, орон нутагт/	969,603	967,136	99.75%
5	Шилэн кабелийн өргөтгөл /Улаанбаатар хот, орон нутагт/	330,500	330,500	100.00%
6	"Цахим оффис үйлчилгээний сервер тоног төхөөрөмжийн өргөтгөл"	240,000	-	-
7	Компьютер түүний дагалдах хэрэгсэл	151,920	147,200	96.89%
8	Автомашин	96,600	96,600	100.00%
9	Гаражийн засвар	150,000	105,000	70.00%
10	АТС-34 барилгын өргөтгөлийн ажил	449,000	449,000	100.00%
	Хөрөнгө оруулалтын дүн	4,647,344	4,468,570	96.15%


Гурав. Удирдлага, бүтэц зохион байгуулалтын талаар

Монгол Улсын Засгийн Газар болон БНСУ-ын “Кореа Телеком” корпорацийн хооронд байгуулагдсан гэрээний дагуу Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн 40 хувийг Монгол Улсын Засгийн газарт худалдах багцын арилжаа 2018 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр явагдсанаар тус компани дахь Монгол Улсын Засгийн газрын эзэмшлийн хувь 94.67 хувьд хүрлээ.

Хувьцаа эзэмшигчид



Хувьцааны ханш, төгрөгөөр



Хувьцаа эзэмшигчдийн хурал

Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны ээлжит хурал 2018 оны 4 дүгээр сарын 30-ний өдөр зохион байгуулагдлаа. Хурлын ирц: 95.46%.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлээ. Үүнд:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт
2. Компанийн 2017 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
3. Компанийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлт
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай
5. ТУЗ-ийн 2018 оны зардлын төсвийг батлах тухай
6. Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах тухай
7. Үл хөдлөх хөрөнгийг данснаас хасах тухай

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гаргасан шийдвэр

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай асуудлыг 99.9991 хувийн саналаар батлав.
2. Компанийн 2017 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай асуудлыг 99.9968 хувийн саналаар батлав.
3. Компанийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлт, Аудитын хорооны дүгнэлтийг батлах тухай асуудлыг 99.9968 хувийн саналаар батлав.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгов.
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны зардлын төсвийг 99.9970 хувийн саналаар батлав.
6. Үл хөдлөх хөрөнгийг данснаас хасах асуудлыг 99.9951 хувийн саналаар батлав.

2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлж, сонгосон бөгөөд ТУЗ нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

ТУЗ-ийн дарга

Ц.Баяр-Эрдэнэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга

Ердийн гишүүд

Г.Эрдэнэбулган ЗГ-ийн хэрэг эрхлэх газар, Хууль, эрхзүйн газар, Засгийн газрын референт

Ж.Цогтбаяр СЯ, СХЭУГ-ын Санхүүгийн хяналт шалгалтын хэлтсийн дарга

Ч.Цэвэгдорж Үндэсний Статистикийн Хороо, Тамгын газрын дарга

Д.Ариунтуяа ХЗДХЯ, Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн дарга

Т.Лхагвасүрэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Хараат бус гишүүд

Ж.Тамир Төр засгийн үйлчилгээ эрхлэх газрын дарга

Л.Болормаа Төрийн банк, Нүний нөөцийн газрын захирал

Ц.Норовжамц Интер аудит ХХК-ийн гэрээт аудитор

Дөрөв. Нийгмийн хариуцлагын хүрээнд

Үзүүлэлтүүд	2017	2018
Ажиллагсдын тоо	768	794
Хөдөлмөрийн зардал, мян.төг	6,555,552	6,431,729
Сургалт, хөгжилд зарцуулсан хөрөнгө, мян.төг	20,658	20,528
Хувьцаа эзэмшигчдийн тоо	3,982	3,986
Нийгэм рүү чиглэсэн арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө, мян.төг	600	11,520
Экологийн хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө, мян.төг	150	-
Хөдөлмөрийн эрүүл ахуй аюулгүй байдлыг хангахад зарцуулсан хөрөнгө, мян.төг	41,696	63,493
Улсад төлж буй татвар, бусад шимтгэл, мян.төг	713,659	721,840
Мэргэжлийн холбоод, нийгмийн сайн сайхны төлөөх байгууллагын гишүүний төлбөр, мян.төг	3,455	14,496

Тав. Санхүүгийн чадавхийн байдал

2018 оны санхүүгийн төлбөрийн чадварыг шинжлэхэд эргэлтийн хөрөнгийн харьцаа 6,2 % байгаа нь нийт эргэлтийн хөрөнгөөр богино хугацаат өр төлбөрөө төлөх чадвар сайн байна. Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа 2017 оны 03 дунджаар өсч 4,3 болсон нь хөрвөх чадвар сайтай хөрөнгө болох мөнгө, ТБҮЦ, авлага зэргээр богино хугацаат өр төлбөрийг төлөх чадвар сайтайг харуулж байна. Санхүүгийн тогтвортой байдлын хувьд, бие даах чадварын коэффициент 0,79 байгаа нь санхүүгийн хувьд бие даан үйл ажиллагаа явуулах сайтай,

санхүүгийн хамаарлын коэффициент 1,27 байгаа нь бусдаас хараат байдалд өртөөгүй зохистой байгааг харуулж байна. Дүгнэн үзэхэд санхүүгийн хувьд хөрөнгийн хөрвөх чадвар сайн, санхүүгийн хувьд бусдаас хамааралгүй, бие даах чадвар сайтай байгаа болно.

Зургаа. Зах зээлд эзлэх байр суурь

Монгол Улсын Засгийн Газар компанийн БНСУ-ын Корей телеком корпорацийн эзэмшиж байсан хувьцааг (компанийн хувьцааны 40 хувь) худалдан авч, нийт хувьцааны 94.67 хувийг төр эзэмших болсон нь төрөөс үйл ажиллагааг бодлогын хэмжээнд дэмжих таатай нөхцөл бүрдэж байна.

МЦХ ХК нь харилцаа холбооны салбарт суурин сүлжээн доторх ярианы ачааллын 74.8 хувь, орох ярианы нийт ачааллын 60.6 хувь, гарах нийт ачааллын 29.6 хувийг тус тус эзэлж байна. Суурин хэрэглэгчийн тоогоороо 26.1 хувийг эзэлж, зах зээлд 2 дугаарт байна.

Дэлхий нийтээр үүрэн утасны хэрэгцээ хурдтай өсч, суурин утасны хэрэглээ эрс буурч байгаа өнөө үед манай компанийн хувьд бид шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх, шинэ техник, технологи, арга зүйгээр инновацид суурилсан стратегийн бодлого хэрэгжүүлэх, үр дүнд суурилсан арга зүй нэвтрүүлэх, судалгаа шинжилгээний ажлуудыг эхлүүлэх хэрэгтэй байна.

***Монголын цахилгаан холбоо ХК
2018 оны 8 дугаар сар.***